



**НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2017 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/08


Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, өмч хамгаалах комиссын хурлын шийдвэрийг үндэслэн **ТУШААХ НЬ:**

1. Гадаадын хөрөнгө оруулалт, зээл тусламжтай холбоотойгоор Паркийн Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг Англи хэл рүү орчуулах ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлсүгэй.
2. Баталгаат орчуулгын газартай хамтран ажиллах гэрээ байгуулахыг Ахлах мэргэжилтэн Н.Пүрэвсүрэнд даалгасугай.
3. Дээрх орчуулгын ажилд нийт 3 000 000 /гурван сая/ төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч Ц.Бямбасүрэнд зөвшөөрсүгэй.

ДАРГА



А.БОЛДБААТАР